



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III
хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1, 52.1.4 дэх заалт, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 4.1.1 дэх заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2025 оны ээлжит V хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдааныг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 09⁰⁰ цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцэхээр тогтсугай. Үүнд:

- 1) “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээ батлах тухай
- 2) “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээ батлах тухай
- 3) “Амар тайван Чингэлтэй-2028” арга хэмжээ батлах тухай
- 4) “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах-2028” арга хэмжээ батлах тухай
- 5) “Чингэлтэйн боловсрол-2028” арга хэмжээ батлах тухай
- 6) “Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд-2028” арга хэмжээ батлах тухай
- 7) “Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээ батлах тухай
- 8) “Соёлтой иргэн-2028” арга хэмжээ батлах тухай
- 9) “Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээ батлах тухай
- 10) “Цахим Чингэлтэй-2028” арга хэмжээ батлах тухай
- 11) “Чингэлтэйд үйлдвэрлэв-2028” арга хэмжээ батлах тухай
- 12) “Тохилог Чингэлтэй-2028” арга хэмжээ батлах тухай
- 13) Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай
- 14) Дүрэм шинэчлэн батлах тухай
- 15) Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

16) Санал уламжлах тухай

17) Төрийн цол, одон медалиар шагнуулах санал уламжлах тухай

(Илтгэгч нь: Дүүргийн Засаг дарга Н.Мандуул)

18) Үндэсний бичгээр хаягжуулах тухай

19) Эрх шилжүүлэх тухай

(Илтгэгч нь: Дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн
дарга бөгөөд Ажлын албаны дарга
П.Баянбаатар)

2.Хуралдаанд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг
Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.

3.Ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэл, зохион байгуулалтыг
хангаж, ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба
(П.Баянбаатар), Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР